

Түншлэгчид Сарлагийн Сайхан Хишиг

Энэ нь Хатгал сумын хэсэг малчдын санаачлагаар байгуулагдсан хоршоо бөгөөд үндсэн зорилго нь нутгийн үүлдрийн сарлагийн ашиг шимээр байгальд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар хоршооны гишүүдийн өрхийн орлогыг нэмэгдүүлэх болон засаглалын ардчилсан сайн хэлбэрийг нутагшуулахад оршино.

Хил хязгааргүй архитекторууд

Хил хязгааргүй архитекторууд ТББ нь Дани улсын хүмүүнлэгийн байгууллага бөгөөд архитектур, хот төлөвлөлтийн асуудлуудыг хөгжлийн гарц хэмээн тодорхойлж, түүнд хувь нэмэр оруулахыг зорьж ажилладаг. Тус байгууллагын үндсэн зорилго нь ядуу буурай хөгжилтэй орнуудын эмзэг, ядуу хүн амд дэмжлэг үзүүлэхэд оршино. Бид архитекторуудын мэргэжлийн томоохон төслүүдийг боловсруулж, ядууралтай тэмцэх талаарх мэдээллийг хүргэж, улмаар байгалийн гамшигт үзэгдлийн үр дагавраас урьдчилан сэргийлэх зорилгоор ажиллаж байна.

www.arkitekterudengraenser.dk

Хил хязгааргүй сүүний фермер

Хил хязгааргүй сүүний фермер ТББ нь Дани улсын байгууллага бөгөөд хөгжиж буй орнуудын зорилтот сүү, сүүн бүтээгдэхүүний чиглэлээрх орон нутгийн жижиг төслүүд, санаачлагуудыг бий болгох болон дэмжлэг үзүүлэх зорилготой. Энэхүү зорилгод нийцүүлэн тус ТББ нь сүү сүүн бүтээгдэхүүний салбарыг мал саах үйл явцаас (сүүний чанар) сүү сүүн бүтээгдэхүүнийг боловсруулах (боловсруулах болон савлах), орон нутгийн зах зээлд эсвэл малчны хотхон дээрээс худалдан борлуулах үйл явц хэмээн тодорхойлж байна.


www.mejerifolkudengraenser.dk

Эколип Сан

Эколип Сан нь 1999 оноос хойш “Хоёр нарны хооронд” ультра марафон гүйлт гэх мэт байгаль орчинд чиглэгдсэн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг төрийн бус байгууллага бөгөөд 2009 онд албан ёсоор байгуулагдсан.

www.ecoLeap.org

Эколип Сан
www.iug.dk



Хөвсгөлийн сүүний
фермийн төсөл
Khovsgol Dairy Project
Nonprofit organization
www.khovsgoldairyproject.org

Хөвсгөлийн сүүний фермерийн төсөл

Хөвсгөлийн сүүний фермерийн төслийн урт хугацааны зорилго нь Монгол улсын хойд хязгаарт орших Хөвсгөл аймгийн Хатгал сумын нүүдэлчин малчдын санаачлан байгуулсан Сарлагийн Сайхан Хишиг Хоршооны эзэмших, үйл ажиллагааг эрхлэн явуулах Сүүний фермерийг байгуулах, улмаар тогтвортой үйл ажиллагааг нь хангахад оршино.

Тус төслийн ойрын хугацааны зорилт нь Сарлагийн Сайхан Хишиг Хоршооны өндөр чанарын сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, гуравдагч этгээдэд худалдан борлуулах чадавхи, боломж болон үйл ажиллагааг сайжруулах явдал юм. Мөн түүнчлэн, хүн амын эрүүл мэндийн ерөнхий мэдлэг боловсролыг дээшлүүлэх болон өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл ахуйн технологи, мал аж ахуйн гаралтай бүтээгдхүүнтэй хэрхэн ажиллах талаарх ойлголт мэдлэгийг олгох сургалтад малчдыг хамруулна.

Тус төсөл нь орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлэх замаар тус бүс нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах нь хурдацтай явагдаж буй хотыг зорьсон их нүүдлийн чиг хандлагыг сааруулах зорилготой.

www.khovsgoldairyproject.org



Агуулга

Хөвсгөл аймаг нь Монгол улсын хойд хэсэгт оршдог ба Азийн хоёр дахь цэнгэг устай /136 км урт, 37 км өргөн/ гүн цэнхэр Хөвсгөл нуурынхаа нэрээр нэрлэгдсэн. 2013 оны байдлаар ажилгүйдлийн түвшин улсын хэмжээнд 7.9% байхад Хөвсгөл аймгийн хувьд 15.1% байгаа нь эдийн засгийн хувьд буурай хөгжилтэй аймгуудын нэг хэмээн тооцогдоход хүрсэн. Тус аймгийн хувьд хүн амын амьжиргааны эх үүсвэр нь мал аж ахуй, бэлчээрийн гарц, түлээ түлш болон бусад байгалийн гаралтай бүтээгдэхүүнээс хамааралтай.

Үндэсний нийт бүтээгдэхүүний 21%-ийг тус аймгийн мал аж ахуй салбар эзэлж, тус аймгийн нийт ажиллах хүн амын 42% тус салбарт ажиллаж байна. Газарзүйн байршлын хувьд далайн түвшнээс 1650-2050 метрийн өндөрт байрладаг, эрс тэс цаг уурын нөхцөл, хахир урт өвөл, хур тунадас бага зэрэг хүчин зүйлс нь газар тариалан эрхлэх боломжийг хязгаарладаг. Жилийн 95-110 өдөрт л фермерийн аж ахуй эрхлэх боломжтой ба газар тариалангийн салбар бүс нутгийн ердөө 1%-ийг эзлэдэг. Аймгийн нийт хүн амын гуравны нэг нь малчин өрх бөгөөд бэлчээрийн гарцаас хамаарч жилийн 4 улирал нүүдэллэж амьдардаг.

Үндэслэл

Монгол улс нь сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон хэрэглээний талаар он удаан жилийн уламжлал түүхтэй ба Монголчуудын хоол хүнсний хэрэглээний 50-100 хувийг сүү, сүүн бүтээгдэхүүн бүрдүүлдэг.

Малчид сүү сүүн бүтээгдэхүүнийг хэрэглээнээс гадна худалдан борлуулах зорилгоор боловсруулдаг, мөн сүү сүүн бүтээгдэхүүний нөхөрлөл хоршоо байгуулан ажиллахыг орон нутаг, үндэсний хэмжээнд дэмждэг хэдий ч сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээлийн эрэлт хангагдаж чадахгүй байна.

29 малчин өрхүүд зохион байгуулалттай нэгдэж Сарлагийн Сайхан Хишиг Хоршоог байгуулж, 63 малчин өрхийг гишүүнээр элсүүлсэн. Үүний үр дүнд малчид цаг уурын эрс тэс нөхцөлд ч мал маллах, үржүүлэх, үр шимийг тогтвортой хүртэх боломжийг хамтдаа бүрдүүлсэн. Ийнхүү хамтран ажиллах нь өрхийн орлогыг нэмэгдүүлээд зогсохгүй нүүдлийн мал аж ахуйд залуу үеийг үргэлжлүүлэн сургахад дэмжлэг болж байна.

Хөвсгөл нутгийн сарлагийн сүү нь чанарын хувьд танигдсан бөгөөд эрүүл ахуй, чанарыг шаардлагыг цаашид зүй зохистой дэмжлэгээр сайжруулж чадвал хүчтэй брэнд болох өндөр магадлалтай.

Ерөнхий зорилго

Хатгал сумын нүүдлийн малчдын амьжиргаа, амьдралын чанарыг дээшлүүлэх.

Ойрын зорилго

Сүүний чиглэлд:

Сүүний чанар, эрүүл ахуй, хадгалалт болон нийлүүлэлтийг сайжруулж, боловсронгуй болгох. Бүтээгдэхүүн нийлүүлэлт болон боловсруулалт. Сүү сүүн бүтээгдэхүүний чиглэлээр мэдлэг олгох.

Байгууллагад:

Хамтын ажиллагаа, сүү сүүн бүтээгдэхүүний нийлүүлэлт болон хадгалалтын горим зэрэг үйл ажиллагааг сайжруулах замаар хоршооны чадавхийг бэхжүүлэх.

Мал аж ахуйн чиглэлд:

Малд үр өгөөжтэй идэш тэжээлийн систем бий болгох, малын хашаа саравчийг сайжруулах, эрс тэс цаг уурын эрсдлээс мал ахуйг сэргийлэх.

2016-18 оны стратеги

1. ССХ хоршоог хөгжүүлэх зорилгоор чадавхийг бэхжүүлэх.
2. Хатгал суманд малчдын сүү, сүүн бүтээгдэхүүн цуглуулж, борлуулах төвийг байгуулах, улмаар ССХ хоршоо жуулчны баазууд болон айлчин гийчдэд өндөр чанартай сүү, сүүн бүтээгдэхүүн борлуулах.
3. Малчдад ариун цэвэр, эрүүл ахуй, сүүний чанарын хяналтын талаарх сургалт, тоног төхөөрөмжийг зүй зохистой ажиллуулан эзэмших талаарх ойлголт мэдлэгийг тус тус олгох.
4. Сүүний фермерийн ирээдүйн хүний нөөцийг бэлдэх чиглэлд сургалтын стратеги боловсруулах. Хатгал сумаас 2 залуу иргэнийг Улаанбаатар хотын Хүнсний технологийн салбарын сургуулиудад суралцуулах.

